

Монгол улсын оновчтой, уян хатан хөгжлийг дэмжихүй

ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА

2014 оны 1 дүгээр сараас 3 дугаар сар

Хураангуй

Энэ судалгаагаар Экологийн Сэквистрэнш Траст (The Ecological Sequestration Trust (TEST)) – ын санаачилсан хөрөнгө оруулалт, шийдвэр төлөвлөлтийг дэмжих цахим програм Платформ Монгол оронд ил тод байдлыг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг төлөвлөх, уян хатан чанарыг тодорхойлох, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад бодит арга зам, шийдэл мөн эсэхийг судлаж байгаа юм. Салбар салбарын олон талт оролцогчоос бүрдсэн бүтэц бий болгож, хувь, олон нийт, төрийн бус байгууллага, донор, олон улсын хандивлагч талууд гээд гурав дахьч салбарын байгууллагыг нэгтгэж ажиллах нь зорилтот, үр дүнтэй төлөвлөлт, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой гэж дүгнэлээ. Цаашилбал, Засгийн газартай яриа хэлэлцээ өрнүүлж, харилцан санаа бодлоо солилцож, үүнийг албан ёсны үүргээ болгож ажиллах учиртай хувь, бусад олон байгууллага чуулсан бүтцийг бүрдүүлж, бэхжүүлэх нь Монголын ард түмний хөгжил дэвшил, соёлын баялаг өв, экологийн түүхээ хадгалан үлдэх, илүү сайн бодлого хөгжилд хөтлөнө.

Монгол Улс хоёр оронтой өсөлт хийгээд их хэмжээний нүүрстөрөгчийн аж үйлдвэрийн хөгжил гэсэн салаа замын уулзварт ирээд байгаа, үүнийг өөрчлөх шаардлагатай байна. Уур амьсгалын өөрчлөлт, асар хурдтай хотжилттой нүүр тулсан энэ цагт нэгдмэл цогц аргаар шийдэх зайлшгүй шаардлагатай гэдгийг Засгийн газар нэгэнт харж, хүлээн зөвшөөрлөө. Байгаль орчинд маш их хор нөлөө үзүүлж байгаа хэдий ч байгаль орчноо хамгаалах, үүний сацуу уул уурхайн салбараас орлого олох, хүний эрүүл мэнд, сайн сайхан амьдралыг тэтгэх, энэ бүхнийг тэнвцвэртэй тэгш хөгжүүлж хараахан чадаагүй байна. Монгол оронд Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах санхүүгийн урамшуулал, хууль эрхзүй, техникийн тодорхойлолтоо цэгцлэх хэрэгцээ бас байгаа юм.

TEST – ийн хөрөнгө оруулалт, шийдвэр төлөвлөлтийн платформ хөтөлбөрийг зохистой суурилуулахад судалгааны гурван асуулт байна. Үүнд: (1) Хөгжлийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ашиглах тогтворжсон загвартай болох хүсэл эрмэлзлэл байна уу, (2) Энэ нь Монгол улсын хувьд тулгамдсан асуудал бол Платформ хөтөрбөрөөр үүнийг шийдэх үү, (3a) Платформ хөтөрбөр экологи, эдийн засаг, нийгмийн байр сууринаас нэгтгэн ажиллах уу, (3b) Тийм загварыг яаж удирдаж, зохицуулах вэ, (3c) Ямар ямар болзошгүй эрсдэлтэй вэ? Энэ асуултад хариулж, 2014 оны 1 – р сараас 3 – р сарын хооронд танхимаар

судалж, Улаанбаатар хотноо хэд хэдэн удаа ажлын айлчлал хийж, хувь, олон нийт, бусад салбараас бүрдсэн 45 удирдах ажилтаны дээд хэмжээний уулзалт семинар зохион байгуулсан юм.

Хөгжлийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад системд суурилсан, тогтвортой хөгжилд чиглэсэн энэ Платформ хөтөлбөр хэрэгтэй талаар Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам өндөр түвшинд сонирхолоо илэрхийлсэн юм. Хувийн хэвшлийнхэн Захирлуудын клуб (CEO klub) – ээр дамжуулан TEST – ийн бодит баримтад үндэслэж эрсдэл бууруулах чадамж, Монгол улсын олон улсын санхүүд нэвтрэх боломжийг сайжруулах гол хөдөлгөгч хүч гэж тодорхойллоо. Монголын Хөгжлийн санг жилд ДНБ – ний 5% - аар байгуулах санхүүгийн загвар бодитой санал байсан гэж Худалдаа, хөгжлийн банк баталсан. Монгол улсын эрдэм шинжилгээний байгууллагууд, тухайлбал Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль, Монгол Улсын Их Сургууль, Эдийн засгийн судалгааны хүрээлэн, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Үндэсний хөгжлийн хүрээлэн, цаашлаад иргэний нийгмийн тэргүүлэгч байгууллага, олон улсын санхүүжүүлэгч байгууллага, жишээ нь Азийн хөгжлийн банк (ADB), Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (JICA), Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC), Дэлхийн банк (WB) болон 3Gi мэдээлэл технологийн байгууллага, түүнчлэн ДЭМБ (WHO), НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр (UNEP), НҮБ – ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP) эдгээр бүх байгууллага TEST – ын чиг хандлага, арга замыг сайн ойлгож, гүнээ дэмжиж байгаагаа илэрхийлсэн юм.

TEST – ийн Платформ загвар нь өр төлбөр, хөрвөх чадварыг макро эдийн засгийн мэргэжлийн аргад үндэслэж, эрсдийг бодит баримтад суурилан тооцно гэдэгт бүгд санал нэг байгаа юм. Платформыг хэвшмэл арга барил, бодлогын шинэчлэлд “хамтын зөвлөл (“collaboratory”)¹ байгуулж ажиллах маш чухал орон зай гэж дүгнэж байна. Үүнээс ч илүүтэйгээр Монгол улсын "Ухаалаг Засгийн газар" санаачилгад үнэлж баршгүй дэмжлэг болох болно. Хамтын зөвлөл нь олон талт байгууллагын, тухайлбал хувийн, эрдэм шинжилгээний, төрийн салбарын тэгш төлөөлөл бүхий, хууль эрхзүйн засаглалт бие заасан байгууллага байх учиртай. Монгол улс Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ (SDSN) үндэсний төв байгуулахыг санал болгоод, одоо ажиллаж буй байгууллагатай, тухайлбал НҮБ-ын БОХ – ийн Ногоон эдийн засгийн түншлэл (PAGE) – ийн үйл ажиллагааг TEST – тэй нэгтгэх хэрэгтэйг зөвлөсөн. Олон улсын санхүүгийн дэмжлэгтэйгээр засгийн газар, яамд хоорондын ажлын барилдлага хөгжиж, Монгол улс TEST – ийн төсөл хэрэгжүүлэгч анхдагч орон болно гэж Эдийн засгийн хөгжлийн яам баталсан билээ. Хотын дарга Бат-Үүл нийслэлийн бүсийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтад TEST – ийн Платформ хөтөлбөрийг хэрэглэх хүсэлтээ илэрхийлсэн юм².

¹ “Collaboratory (Хамтын зөвлөл)” нь TEST – ын үйл ажлыг нэгтгэж, уялдуулан зохицуулах засаглал гэсэн утга бүхий collaboration, laboratory гэдэг 2 англи үгнээс бүтсэн, TEST – ын зохиосон нийлмэл үг юм.

² Энэ хүсэлтийг 2014 оны 5-р сарын 21-24 Монгол улсад зохион байгуулсан ажлын ганцаарчилсан уулзалтын үеэр Хотын захирагч Бат-Үүл Peter Head – ээс хүссэн билээ.